



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.010>

Information Influence Vulnerabilities and Information Resilience in the Defence Sector

Bayartogtokh Nergui¹, Tumurbat Uranchimeg²

¹Colonel, Ph.D., Associate Professor, Chief of Policy Analysis center, Defense Research Institute of Mongolia, E-mail address: bnergui8119@gmail.com, ORCID:0009-0009-0276-2125

²Researcher, Policy Analysis center, Defense Research Institute of Mongolia, E-mail address: turnaa0808@gmail.com, ORCID:0009-0009-5492-9791

Received: 16 June 2026
Accepted: 28 June 2026

Revised: 22 June 2026
Published online: 28 July 2026



ABSTRACT

In the contemporary security environment, information has become one of the strategic instruments and factors influencing public trust, institutional reputation, policy decisions, the psychological well-being and discipline of service personnel, and operational readiness. The development of the digital environment has expanded opportunities for the dissemination of information; however, it has also increased the risks associated with false, misleading, and decontextualized content, fake online accounts, coordinated comments, artificial intelligence-generated images, voices, and texts, as well as emotionally driven information manipulation. Information manipulation refers to deliberate efforts to influence public opinion, attitudes, and decision-making through the selective use, distortion, concealment, or exaggeration of factual and false information (European External Action Service, 2025; Organisation for Economic Co-operation and Development, 2024).

Criminal offences, disciplinary violations, non-statutory relations, and incidents involving the health or loss of life of service personnel within Mongolia's defence sector and state military organizations are, first and foremost, real issues concerning human rights, occupational safety, command responsibility, and internal oversight. Such matters should not be concealed or regarded solely as direct risks to an institution's reputation. Nevertheless, the use of information related to actual incidents and violations to create vulnerability through exaggerated or misleading interpretations, unverified sources, emotionally provocative content, and the portrayal of an individual case as representative of the entire sector constitutes a vulnerable condition that may be exploited in information influence operations.

The purpose of this article is to analyse, from theoretical, methodological, and practical perspectives, the risks of information influence that exploit both genuine and fabricated vulnerabilities in the defence sector. It seeks to identify the relevant actors, objectives, techniques, and effects of such influence, as well as the directions for strengthening the information resilience of citizens and military personnel and improving institutional response measures. The study employs document analysis, comparative analysis, content analysis, case-study methods, risk assessment, and a results-based approach.

Keywords: defence sector; information influence; information vulnerability; disinformation; misleading information; influence operations; military personnel; information resilience; non-statutory relations; risk management.

Батлан хамгаалах салбарын мэдээллийн нөлөөллийн эмзэг байдал ба мэдээллийн дархлаа

Баяртогтох Нэргүй¹, Төмөрбат Уранчимэг²

¹Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Бодлогын дүн шинжилгээний төвийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа, bnergui8119@gmail.com,
ORCID:0009-0009-0276-2125

²Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Бодлогын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр, turnaa0808@gmail.com, ORCID:0009-0009-5492-9791

ХУРААНГУЙ

Орчин үеийн аюулгүй байдлын орчинд мэдээлэл нь олон нийтийн итгэл, хандлага, байгууллагын нэр хүнд, бодлогын шийдвэр, алба хаагчдын сэтгэл зүй, сахилга, үйл ажиллагааны бэлэн байдалд нөлөөлөх стратегийн арга хэрэгсэл, хүчин зүйлийн нэг болсон. Цахим орчны хөгжил нь мэдээлэл түгээх боломжийг өргөжүүлсэн боловч худал, төөрөгдүүлсэн, нөхцөл байдлаас хэтийдүүлсэн агуулга, хуурамч цахим хаяг, зохиомол сэтгэгдэл, хиймэл оюунаар бүтээсэн дүрс, дуу хоолой, бичвэр болон сэтгэл хөдлөлд суурилсан мэдээллийн манипуляци (бодит болон худал мэдээллийг сонгон ашиглах, гуйвуулах, нуух, хэтрүүлэх замаар олон нийтийн санаа бодол, хандлага, шийдвэрт зориудаар нөлөөлөх ажиллагаа) түгээх эрсдэлийг нэмэгдүүлсээр байна (European External Action Service, 2025; Organisation for Economic Co-operation and Development, 2024).

Монгол Улсын батлан хамгаалах салбар болон төрийн цэргийн байгууллагад гарч буй гэмт хэрэг, сахилгын зөрчил, дүрмийн бус харилцаа, алба хаагчдын эрүүл мэнд, амь нас хохирсон тохиолдол нь юуны өмнө хүний эрх, аюулгүй ажиллагаа, удирдлагын хариуцлага, дотоод хяналтын бодит асуудал, мэдээлэл юм. Ийм асуудлыг нуун дарагдуулах, эсхүл зөвхөн байгууллагын нэр хүндийн шүүд эрсдэл гэж авч үзэхгүй байх шаардлагатай. Гэвч бодит хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг ашиглан эмзэг байдал үүсгэж хэтийдүүлсэн, төөрөгдүүлсэн тайлбар, баталгаагүй эх сурвалж, сэтгэл хөдлөл өдөөсөн агуулга, нэг тохиолдлыг бүхэл салбарын нийтлэг дүр зураг болгон тайлбарлах хандлага нь мэдээллийн нөлөөллийн ажиллагаанд ашиглагдах эмзэг нөхцөл болдог.

Энэхүү өгүүллийн зорилго нь батлан хамгаалах салбарын бодит болон хуурмаг эмзэг асуудлыг ашигласан мэдээллийн нөлөөллийн эрсдэлийг онол, арга зүй, бодит нөхцөлийн үүднээс шинжилж, нөлөөллийн субъект, зорилго, арга техник, үр нөлөө, иргэд, цэргийн алба хаагчдын мэдээллийн дархлаа болон байгууллагын хариу арга хэмжээний чиглэлийг тодорхойлоход оришино. Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, харьцуулсан шинжилгээ, агуулгын шинжилгээ, кейсийн арга, эрсдэлийн үнэлгээ, үр дүнд суурилсан хандлагыг ашиглав.

Түлхүүр үгс: батлан хамгаалах салбар, мэдээллийн нөлөөлөл, мэдээллийн эмзэг байдал, худал мэдээлэл, төөрөгдүүлсэн мэдээлэл, нөлөөллийн ажиллагаа, цэргийн алба хаагч, мэдээллийн дархлаа, дүрмийн бус харилцаа, эрсдэлийн удирдлага.

УДИРТГАЛ

Мэдээлэл нь орчин үеийн аюулгүй байдлын орчинд зөвхөн мэдлэг дамжуулах хэрэгсэл байхаа больж, олон нийтийн ойлголт, нийгмийн сэтгэл зүй, бодлогын шийдвэр, байгууллагын нэр хүнд, улсын тогтвортой байдалд нөлөөлөх стратегийн арга хэрэгсэл, нөөц болсон. Цахим сүлжээ, мэдээний хуудас, дүрс бичлэгийн платформ, шуурхай харилцааны сувгууд нь мэдээллийг богино хугацаанд өргөн хүрээнд түгээх боломж бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ баталгаагүй, гуйвуулсан, санаатайгаар төөрөгдүүлэх агуулга олон дахин давтагдан түгж, бодит мэт хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл бий болдог (Organisation for Economic Co-operation and Development, 2024; European External Action Service, 2025).

Батлан хамгаалах салбар нь үндэсний аюулгүй байдал, төрийн болон албаны, цэргийн нууц, зэвсэгт хүчний бэлэн байдал, хүний нөөц, сахилга, иргэн-цэргийн харилцаатай шууд холбогддог ороо мэдээллийн нөлөөлөлд нэн тэргүүнд онилогддог, мэдрэмтгий салбар юм. Тэр ч утгаараа цэргийн салбар, цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд, дүрмийн бус харилцаа, сахилгын зөрчил, хангамж, цалин, алба хаах нөхцөл, удирдлагын хариуцлагатай холбоотой аливаа хэрэг, үйл явдал нь олон нийтийн анхаарал, сэтгэл хөдлөлийг хүчтэй татдаг, түүнтэй холбоотой үр дагавар нь чухал онцлогтой, эерэг, сөрөг нөлөөтэй байдаг. (Black et al., 2020; European External Action Service, 2025)

Монгол Улсын төрийн цэргийн байгууллагад дүрмийн бус харилцаа, алба хаагчийн эрх зөрчигдөх, эрүүл мэнд болон амь насанд нь эрсдэл учрахтай холбоотой асуудал нь өндөр анхааралд байх, шууд манипуляци гэж үзэж болохгүй бодит хяналт, бодит хариуцлага, бодит шинэчлэл шаардсан асуудал юм. Монгол Улсын Их Хурлын мэдээлэлд сүүлийн арван жилийн хугацаанд цэргийн анги, байгууллагад 468 гэмт хэрэг, сахилгын зөрчил бүртгэгдэж, хамгийн багадаа 44 хүний амь нас хохирсон талаар танилцуулсан байдаг. Түүнчлэн хугацаат цэргийн алба хаагчийн амь нас хохирсон 20, эрүүл мэнд хохирсон 126, дүрмийн бус харилцаанд өртсөн 105, цэргийн албанаас оргон зайлсан 56 тохиолдлыг дурдсан байна. Эдгээр үзүүлэлт нь тухайн үеийн бүртгэл, ангилал, хамрах хугацаатай холбоотой тул цэргийн салбарын өнөөгийн байдлыг бүхэлд нь илэрхийлэх хэмжүүр биш боловч хүний эрх, дотоод хяналт, сахилга, аюулгүй ажиллагааны асуудлыг бодитой авч үзэх шаардлагатайг харуулна (Монгол Улсын Их Хурал, 2021, 2022; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2022).

Энэхүү судалгаа нь цэргийн салбарт гарсан бодит хэрэг, зөрчлийг гадаадын эсхүл дотоодын тодорхой субъект зохион байгуулсан нөлөөллийн ажиллагаа гэж шууд дүгнэхгүй. Харин бодит хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг ашиглан байгууллагын нэр хүнд, иргэдийн итгэлцэл, алба хаагчдын сэтгэл зүй, цэргийн албаны нийгмийн үнэлэмж, бэлэн байдал, дайчилгааны нөөцийн сэтгэл зүйн тогтвортой байдалд нөлөөлөх эрсдэл хэрхэн үүсэж болохыг судална.

Нэг. Онол, арга зүйн үндэс

1. Худал, төөрөгдүүлсэн болон сөрөг зорилгоор ашигласан мэдээлэл

Мэдээллийн эмх замбараагүй байдлын онолын дагуу гурван үндсэн ойлголтыг ялган авч үздэг. Нэгдүгээрт, санамсаргүй ташаа мэдээлэл гэж буруу боловч хор учруулах санаагүйгээр түгээгдсэн мэдээллийг хэлнэ. Тухайлбал, иргэн хуучин зураг, бичлэгийг шинэ үйл явдал гэж эндүүрэн хуваалцах, эх сурвалжийг шалгалгүй дамжуулах зэрэг нь энэ хэлбэрт хамаарна (Wardle & Derakhshan, 2017; Council of Europe, 2017).

Хоёрдугаарт, зориудаар төөрөгдүүлэх мэдээлэл нь тодорхой хүн, байгууллага, нийгмийн бүлэг, улс орны талаарх ойлголтод нөлөөлөх зорилгоор худал эсхүл гуйвуулсан агуулгыг санаатайгаар боловсруулах, түгээх үйл ажиллагаа юм (Wardle & Derakhshan, 2017; Council of Europe, 2017).

Гуравдугаарт, төөрөгдүүлсэн болон сөрөг зорилгоор ашигласан бодит мэдээлэл гэж бодит баримт, зураг, бичлэг, хувийн мэдээлэл, албаны баримтыг хууль бус, ёс зүйгүй, хор хохирол учруулах зорилгоор нөхцөл байдлаас салган ашиглахыг хэлнэ

(Wardle & Derakhshan, 2017; Council of Europe, 2017).

Цэргийн салбарт эдгээр хэлбэр нь тус тусдаа болон давхар илэрч болно. Бодит хэрэг гарсан тохиолдолд анхны эх сурвалж нь үнэн байж болох боловч түүнтэй хамааралгүй хуучин зураг, бичлэг нэмж тараах, мөрдөн шалгах ажиллагаанаас өмнө буруутан болон шалтгааныг тогтоосон мэт тайлбарлах, нэг ангийн асуудлыг бүх батлан хамгаалах салбарын мөн чанар болгон тайлбарлах зэргээр төөрөгдүүлсэн агуулга үүсэж болно.

Иймээс тухайн мэдээлэл үнэн эсэхийг дангаар нь үнэлэхээс гадна ямар нөхцөлд, ямар зорилтот бүлэгт, ямар хэлбэрээр, ямар давтамжтайгаар, ямар үр дагавартайгаар түгээгдэж байгааг цогцоор нь судлах шаардлагатай (European External Action Service, 2025, 2026).

2. Мэдээллийн нөлөөллийн ажиллагааны ойлголт

Мэдээллийн нөлөөллийн ажиллагаа гэдэг нь тодорхой зорилтот бүлгийн ойлголт, хандлага, итгэл үнэмшил, шийдвэр, зан үйлд мэдээллийн орчныг ашиглан чиглэсэн нөлөө үзүүлэх оролдлого юм. Энэ нь дан ганц худал мэдээ түгээхтэй адил бус бөгөөд бодит баримтыг сонгон ашиглах, үнэн мэдээллийг нөхцөл байдлаас салгах, сэтгэл хөдлөл өдөөх, хуурамч эрх мэдэл бий болгох, зохиомол олон нийтийн санал бодол үүсгэх, айдас болон үл итгэх байдлыг гүнзгийрүүлэх зэрэг олон аргаар хэрэгжинэ (Black et al., 2020; European External Action Service, 2025).

Нөлөөллийн ажиллагааны гол зорилго нь заавал тодорхой нэг баримтыг үнэмшүүлэхэд оршдоггүй. Илүү урт хугацааны зорилго нь “албан ёсны мэдээлэлд итгэх боломжгүй”, “байгууллага бүх зүйлийг нуудаг”, “асуудал хэзээ ч шийдэгдэхгүй” гэх ерөнхий үл итгэх байдлыг бий болгоход чиглэж болно (European External Action Service, 2025; Organisation for Economic Co-operation and Development, 2024).

Европын Холбооны Гадаад харилцааны алба гадаад мэдээллийн төөрөгдүүлэлт, хөндлөнгийн оролцооны эрсдэлийг судлахдаа зөвхөн нэгж худал мэдээг бус, өгүүлэмжийн уялдаа, цахим дэд бүтэц, түгээлтийн хугацаа, хаягуудын сүлжээ, давтан түгээлтийн хэв шинж, зорилтот бүлэгт үзүүлсэн нөлөөг хамтатган үнэлдэг (European External Action Service, 2025, 2026).



Зураг 1. Бодит хэрэг, мэдээллийн хоосон орон зай ба нөлөөллийн эрсдэлийн уялдаа

Батлан хамгаалах салбарын хувьд нөлөөллийн ажиллагааны бай нь зөвхөн нууц баримт бичиг, зэвсэг техник, цэргийн мэдээ, холбооны сүлжээ, байгууллагын

дотоод мэдээлэл биш юм. Батлан хамгаалах салбарын байгууллага, цэргийн анги, удирдлага, алба хаагчид, тэдгээрийн ар гэр, олон нийт, цэргийн албаны талаарх нийгмийн ойлголт, батлан хамгаалах бодлогод итгэх итгэл, хандлага нь нөлөөллийн боломжит бай болж болно (Black et al., 2020; European External Action Service, 2025).

3. Мэдээллийн дархлааны ойлголт

Мэдээллийн дархлаа нь хувь хүн, байгууллага, нийгэм худал, төөрөгдүүлсэн, дайсагнасан болон эрсдэлтэй мэдээллийг таних, эх сурвалжийг нягтлах, хариуцлагатай хандах, түгээхээс татгалзах, сөрөг нөлөөг нь бууруулах мэдлэг, чадвар, хандлага, зохион байгуулалтын чадавхын нэгдэл юм (Organisation for Economic Co-operation and Development, 2024).

Цэргийн алба хаагчийн мэдээллийн дархлааг дараах таван бүрэлдэхүүнээр тодорхойлж болно.

Бүрэлдэхүүн	Агуулга
Мэдлэг	Худал мэдээлэл, кибер аюулгүй байдал, нууцлал, цахим ёс зүйн суурь ойлголт
Шүүн тунгаах чадвар	Эх сурвалж, огноо, баримт, зураг, бичлэг, дуу хоолойн бодит байдлыг нягтлах
Зан үйлийн төлөвшил	Баталгаагүй мэдээлэл түгээхгүй байх, нууцлал хамгаалах, журам мөрдөх
Сэтгэл зүйн тогтвортой байдал	Айдас, бухимдал, гомдол, цуурхалд авталгүй бодитой дүгнэх
Байгууллагын дэмжлэг	Сургалт, сэрэмжлүүлэг, албан ёсны суваг, хяналт, шуурхай хариу тогтолцоо

Мэдээллийн дархлаа нь зөвхөн нэг алба хаагчийн мэдлэгийн асуудал биш юм. Удирдлагын харилцаа, дотоод мэдээллийн урсгал, гомдол мэдээлэх тогтолцоо, сэтгэл зүйн үйлчилгээ, нууцлалын соёл, хариу арга хэмжээний шуурхай байдал нь мэдээллийн дархлааг тодорхойлох байгууллагын хүчин зүйл болно (Organisation for Economic Co-operation and Development, 2024; United Nations Peacekeeping, 2024).

Хоёр. Батлан хамгаалах салбарын мэдээллийн нөлөөлөлд өртөж болох чиглэл

Батлан хамгаалах салбарын мэдээллийн нөлөөлөлд өртөж болох үндсэн чиглэлд дараах асуудал багтана.

- Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдал;
- Хамт олны итгэлцэл, дотоод уур амьсгал;
- Сахилга, хариуцлага, нууцлалын соёл;
- Цэргийн албаны талаарх олон нийтийн ойлголт;
- Удирдлагын шийдвэр, томилгоо, захиргааны үйл ажиллагааны талаарх үнэлэмж;
- Батлан хамгаалах салбарын байгууллага, цэргийн ангийн нэр хүнд;
- Алба хаагчдын ар гэр, ойр дотнын хүмүүсийн хандлага;

- Иргэн-цэргийн харилцаанд суурилсан олон нийтийн итгэл;
- Цэргийн сургалт, бэлтгэл, өдөр тутмын болон байлдааны бэлэн байдал;
- Судалгаа, төлөвлөлт, удирдлага, дотоод зохион байгуулалтын үндсэн ажил;
- Шийдвэр гаргалтын шуурхай байдал, ажлын тасралтгүй ажиллагаа;
- Дайчилгааны бэлэн байдал болон дайчилгааны нөөц бүрэлдэхүүний нийгмийн сэтгэл зүй, ойлголт, хандлага.

Батлан хамгаалах салбарын байгууллага, цэргийн ангийн хувьд нөлөөллийн ажиллагааны нэг боломжит зорилго нь байгууллагын үндсэн чиг үүрэг, сургалт бэлтгэл, бэлэн байдал, судалгаа, төлөвлөлт, удирдлагын шийдвэр гаргалтыг сарниулах явдал байж болно. Баталгаагүй гомдол, хэт дэвэргэгдсэн агуулга, зохиомол маргаан, давтамжтай сөрөг мэдээлэл нь байгууллагын удирдлага, мэргэжилтэн, алба хаагчдыг тайлбар өгөх, баримт цуглуулах, шалгалт зохион байгуулах, гомдол шийдвэрлэх, тайлагнах, захиргаа, зохион байгуулалтын ажилд хэт төвлөрүүлэх эрсдэл үүсгэдэг (Black et al., 2020; European External Action Service, 2025).

Ийм нөхцөлд байгууллагын цаг хугацаа, хүний нөөц, удирдлагын анхаарал, санхүү болон зохион байгуулалтын чадавх нь үндсэн үүргээсээ хөндийрч болзошгүй. Өөрөөр хэлбэл, цэргийн анги, байгууллага бэлэн байдал, сургалт, мэргэжлийн ажил, төлөвлөлт, судалгаа, өдөр тутмын үйл ажиллагаандаа зориулах ёстой нөөцөө тайлбар, шалгалт, давхар тайлагнал, захиргаа, зохион байгуулалтын ажиллагаанд зарцуулах нөхцөл үүсэж болно.

Энэ нь тухайн сөрөг мэдээлэл бүр нөлөөллийн ажиллагаа мөн гэсэн дүгнэлт биш юм. Харин бодит бус, нөхцөл байдлаас салгасан, давтамжтай, уялдаатай, сэтгэл хөдлөл өдөөсөн мэдээллийн урсгал нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг сарниулах, шийдвэр гаргах хурдыг сааруулах, дотоод итгэлцлийг сулруулах, бэлэн байдлын сургалт, төлөвлөлт, үндсэн үйл ажиллагаанд зориулах нөөцийг багасгах эрсдэлтэй (European External Action Service, 2025, 2026).



Зураг 2. Нөлөөллийн ажиллагааны боломжит ерөнхий механизм

Гурав. Нөлөөллийн ажиллагааны арга техник

1. Агуулгыг нөхцөл байдлаас салгах, хагас үнэн ашиглах

Энэ арга нь бодит зураг, дүрс бичлэг, тоо баримт, баримт бичгийн хэсгийг ашиглах боловч түүний үүссэн шалтгаан, цаг хугацаа, газар орон, холбогдох тайлбар, албан ёсны баримт, бодит нөхцөл байдлыг орхигдуулан түгээх хэлбэр юм. Ийм агуулга нь бүхэлдээ зохиомол худал мэдээллээс илүү үнэмшилтэй харагдах магадлалтай. Учир нь мэдээлэл дотор тодорхой хэмжээний бодит элемент агуулагддаг ([Wardle & Derakhshan, 2017](#); [Council of Europe, 2017](#)).

Батлан хамгаалах салбарт хуучин сургалтын бичлэгийг одоогийн үйл явдал мэт түгээх, нэгжийн түвшний асуудлыг салбарын нийтлэг нөхцөл байдал болгон дүгнэх, ганц тохиолдлыг тогтолцооны доголдол мэтээр тайлбарлах, тухайн ангийн дотоод асуудлыг бүх цэргийн байгууллагын хэв шинж гэж дүгнэх зэрэг нь хагас үнэн ашигласан нөлөөллийн эрсдэлт хэлбэр юм.

Илрүүлэх үндсэн шинж нь эх сурвалж тодорхой бус байх, зураг бичлэгийн огноо болон байршил зөрөх, гарчиг нь агуулгаасаа хэт дэвэргэгдсэн байх, нэг эх сурвалжийг олон хаяг давтан ашиглах, албан ёсны тайлбар болон бодит баримттай зөрчилдөх зэрэг болно ([European External Action Service, 2025, 2026](#)).

2. Сэтгэл хөдлөл өдөөсөн агуулгаар анхаарал татах

Нөлөөллийн агуулга нь айдас, уур бухимдал, гомдол, үл итгэх байдал, эх оронч сэтгэл, өрөвдөх сэтгэл, эмзэглэлийг ашиглан хүлээн авагчийн шүүн тунгаах чадварыг сулруулахыг зорьдог. Ийм агуулгад “нууж байна”, “үнэн ил боллоо”, “аюул учирлаа”, “бүгд мэдэж байгаа”, “иргэдийг хуурч байна”, “байгууллага хариуцлага хүлээхгүй байна” гэх мэт туйлширсан, баталгаагүй, сэтгэл хөдлөл өдөөсөн үг хэллэг түгээмэл хэрэглэгддэг ([Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

Батлан хамгаалах салбарын хувьд цэргийн албаны нөхцөл, цалин хангамж, хүний эрх, осол зөрчил, томилгоо, зэвсэг техник, нууцлал, сахилга хариуцлага зэрэг нь олон нийтийн анхааралд өртөмтгий сэдэв болдог. Ийм учраас эдгээр асуудлаар үнэн зөв, цаг үеэ олсон, ойлгомжтой мэдээлэл хүргэх нь мэдээллийн эрсдэлийг бууруулах чухал нөхцөл болно.

Сэтгэл хөдлөл өдөөсөн агуулга нь байгууллагын дотоод орчинд алба хаагчдын бухимдал, үл ойлголцол, үл итгэх байдлыг нэмэгдүүлж, улмаар сахилга хариуцлага, хамтын ажиллагаа, удирдлагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.

3. Зохиомол олон нийтийн санал бодол бий болгох

Нэг ижил санаа, хэллэг, түлхүүр үг, зураг, тайлбарыг богино хугацаанд олон цахим хаяг, хуудас, сэтгэгдэл, хэлэлцүүлгээр давтан түгээх нь тухайн санаа бодит олон нийтийн байр суурь мэт ойлголт төрүүлэх боломжтой. Энэ нь зохион байгуулалттай оролцооны шинжийг илэрхийлж болох боловч зөвхөн давтамжид тулгуурлан зохион байгуулагчийг тогтоох нь үндэслэлгүй юм ([European External Action Service, 2025, 2026](#)).

Ийм тохиолдолд олон хаяг ижил өгүүлбэр, ижил алдаа, ижил зураг ашиглаж байгаа эсэх; нийтлэх цаг хугацаа нэг дор давхцаж байгаа эсэх; тухайн хаягууд

зөвхөн нэг төрлийн маргаантай сэдвээр идэвхэждэг эсэх; бодит хувийн агуулга, харилцааны түүх бага эсэх; хаягуудын харилцан дэмжлэг, дахин түгээлтийн сүлжээ байгаа эсэх; эх сурвалжийн гарал, цахим хаягийн үүссэн хугацаа, үйл ажиллагааны түүхийг хамтад нь шинжлэх шаардлагатай ([European External Action Service, 2025, 2026](#)).

4. Хуурамч эрх мэдэл, “дотоод эх сурвалж” ашиглах

Энэ арга нь шинжээч, сэтгүүлч, алба хаагч, гэрч, дотоод эх сурвалж, нууц мэдээлэлтэй хүн гэх дүр эсгэсэн цахим хаяг, сувгийг ашиглан итгэл төрүүлэхийг зорьдог. Зарим тохиолдолд бодит байгууллагын нэр, бэлгэ тэмдэг, албан бичгийн хэлбэр, албан тушаалтны зураг, мэдэгдлийн хэв маягийг дуурайж ашиглаж болно ([European External Action Service, 2025](#); [Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

“Дотоод эх сурвалж мэдээллээ”, “баттай хүнээс сонслоо”, “найдвартай эх сурвалж хэллээ” гэх боловч баримтаар баталгаажаагүй мэдээ нь мэдээллийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Ялангуяа хүний амь нас, эрүүл мэнд, гэмт хэрэг, цэргийн нууцлал, анги салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлд баталгаажуу дүгнэлт хийх нь хохирогч, ар гэр, алба хаагч, шалгалтын ажиллагаа болон олон нийтийн итгэлцэлд зэрэг сөрөг нөлөө үзүүлж болно.

5. Хиймэл оюунаар бүтээсэн хуурамч дүрс, дуу, бичвэр

Хиймэл оюунд суурилсан технологи нь хүний дүр төрх, дуу хоолой, хэл найруулга, бичлэгийн хэлбэрийг дуурайх боломжийг нэмэгдүүлж байна. Ийм технологи ашиглан албан тушаалтан, удирдлага, алба хаагчийн нэрээр хуурамч мэдэгдэл, дуу хоолой, дүрс бичлэг, захидал, тушаалын төсөл мэт агуулга тараах эрсдэл бий ([Organisation for Economic Co-operation and Development, 2024](#); [Монгол Улс, 2021](#)).

Батлан хамгаалах салбарт удирдах албан тушаалтан, цэргийн ангийн захирагч, алба хаагчийн нэрээр хуурамч мэдэгдэл гаргах, дүрс болон дууг дуурайх, хуурамч тушаал, баримт бичиг, захирамж мэт агуулга тараах, цэргийн анги болон байгууллагын үйл ажиллагааны талаар ташаа ойлголт бий болгох хэлбэрээр энэ эрсдэл илэрч болзошгүй.

Хуурамч дүрс болон дууны агуулгыг зөвхөн техникийн чанараар нь үнэлэх нь хангалтгүй. Харин тухайн мэдээлэл албан ёсны сувгаар гарсан эсэх, анхны эх сурвалж хаана байршиж байгаа, огноо цагийн зөрчил байгаа эсэх, бусад найдвартай эх сурвалжаар баталгаажих эсэхийг шалгах шаардлагатай ([Монгол Улс, 2021](#); [Монгол Улсын Засгийн газар, 2022](#)).

6. Мэдээллийн хоосон орон зайг ашиглах

Байгууллагаас асуудалтай холбоотой тайлбар, бодит мэдээлэл, албан ёсны байр суурийг цаг тухайд нь өгөхгүй бол цуурхал, таамаг, баталгаажуу мэдээлэл түгэх нөхцөл бүрддэг. Ийм орон зайд нөлөөллийн агуулга өөрийн тайлбарыг “цорын ганц үнэн” мэтээр танилцуулах боломжтой болдог ([European External Action Service, 2025](#); [Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

Мэдээллийн хоосон орон зай нь зөвхөн олон нийттэй харилцах ажлын сул

тал биш юм. Энэ нь байгууллагын аюулгүй байдал, нэр хүнд, итгэлцэл, дотоод уур амьсгал, алба хаагчдын сэтгэл зүй, удирдлагын шийдвэр гаргалт, цэргийн бэлэн байдалд дам нөлөөлөх эрсдэлийн хүчин зүйл болно.

Дөрөв. Нөлөөллийн ажиллагааг хэрэгжүүлж болзошгүй субъект

1. Субъектийн онолын ангилал

Орчин үеийн цахим мэдээллийн орчинд нөлөөллийн ажиллагааг зөвхөн нэг улс, тусгай алба, эсхүл төвлөрсөн удирдлагатай зохион байгуулалттай бүлэг хэрэгжүүлдэг гэж хязгаарлан ойлгох нь учир дутагдалтай. Мэдээллийн агуулгыг санаачлагч, боловсруулах, түгээх, давтан түгээх, түгээлтийг эрчимжүүлэх болон түүнээс ашиг хүртэгч субъект харилцан адилгүй байж болно (Black et al., 2020; European External Action Service, 2025, 2026).



Зураг 3. Нөлөөллийн ажиллагаанд оролцож болзошгүй субъектийн харилцан уялдаа

Өөрөөр хэлбэл, аливаа сөрөг мэдээллийг анх нийтэлсэн субъект нь түүнийг өргөн хүрээнд тараасан субъект байх албагүй. Мөн мэдээллийг түгээсэн субъект нь тухайн агуулгын улс төр, эдийн засаг, нэр хүндийн үр ашгийг хүртэгч субъекттэй шууд холбоотой байхгүй байж болно.

Субъектийн төрөл	Боломжит зорилго	Хэрэглэж болох арга хэлбэр	Болзошгүй эрсдэл
Гадаад улсын төрийн болон түүнтэй холбоотой бүтэц	Улс төр, аюулгүй байдлын орчинд нөлөөлөх, төрийн байгууллагад итгэх итгэлийг сулруулах	Давтамжтай сөрөг өгүүлэмж, хуурамч хаяг, зохиомол эх сурвалж, олон сувгийн түгээлт	Батлан хамгаалах чадавх, төрийн байгууллага, цэргийн албанд үл итгэх хандлага бий болох
Төрийн бус зохион байгуулалттай сүлжээ	Үзэл суртал, улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг дэмжих	Зориудаар бэлтгэсэн сэтгэгдэл, сонгомол баримт, хагас үнэн, давтамжтай түгээлт	Нийгмийн талцал, цуурхал, сөрөг хандлага, үл ойлголцол нэмэгдэх

Дотоодын улс төрийн болон ашиг сонирхлын бүлэг	Өрсөлдөгч талын нэр хүндийг сулруулах, бодлогын дарамт бий болгох	Нэг тохиолдлыг хэт хэтийдүүлэх, баримтыг сонгон ашиглах, улс төрийн өнгө аяс оруулах	Батлан хамгаалах асуудал хэт улс төржих, мэргэжлийн шийдвэр гаргалтад дарамт учрах
Ашиг хонжоо хайсан цахим сүлжээ, мэдээлэл бүтээгч	Хандалт, дагагч, сурталчилгааны орлого, цахим нэр хүнд олох	Дэвэргэгдсэн гарчиг, баталгаагүй дотоод эх сурвалж, сэтгэл хөдлөл өдөөсөн бичлэг, шууд дамжуулалт	Буруу мэдээлэл хурдацтай тархах, хохирогч болон ар гэрт давхар сэтгэл зүйн хохирол учрах
Хувь хүн, оролцогч, дотоод мэдээлэл дамжуулагч	Хувийн гомдол, бухимдал, үзэл бодол, ашиг сонирхлоо илэрхийлэх	Нууцлалын журам зөрчсөн зураг, бичлэг, баталгаагүй тайлбар, дотоод баримт задруулах	Мэдээлэл алдагдах, шалгалтад саад учрах, дотоод уур амьсгал доройтох
Санамсаргүй дахин түгээгч	Үнэн зөвийг шалгалгүй мэдээлэл хуваалцах, сэтгэл хөдлөлөөр хариу үзүүлэх	Нийтлэл, бичлэг, сэтгэгдэл, цуурхлыг давтан түгээх	Худал, төөрөгдүүлсэн мэдээлэл аяндаа өргөн хүрээнд тархах

2. Субъектийн зорилгыг тодорхойлох арга зүй

Нөлөөллийн ажиллагааны зорилгыг зөвхөн нэг нийтлэлийн агуулга, нэг цахим хаяг, эсхүл нэг удаагийн сөрөг сэтгэгдэлд тулгуурлан тогтоох боломжгүй. Учир нь хүний эрхийн асуудал хөндсөн шүүмжлэл, иргэний хяналт, сэтгүүл зүйн эрэн сурвалжилга, хохирогчийн ар гэрийн байр суурь болон зохион байгуулалттай мэдээллийн нөлөөлөл нь гаднаас харахад ижил төстэй шинжтэй байж болно ([European External Action Service, 2025, 2026](#)).

Иймээс аливаа агуулгыг дараах дөрвөн шалгуураар хамтатган үнэлнэ.

Нэгдүгээрт, өгүүлэмжийн чиглэлийг үнэлнэ. Тухайн агуулга бодит хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, буруутай этгээдийн хариуцлага, хохирогчийн эрх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төвлөрч байна уу, эсхүл нэг анги, нэг алба хаагч, нэг удирдлага, нэг тохиолдлын асуудлыг бүх батлан хамгаалах салбарын мөн чанар мэтээр тайлбарлаж байна уу гэдгийг ялгана.

Хоёрдугаарт, мэдээлэл түгсэн хэв шинжийг үнэлнэ. Ижил гарчиг, ижил зураг, ижил үг хэллэг, ижил дүгнэлт, ижил сэдэвчилсэн тэмдэг, ижил сэтгэгдэл богино хугацаанд олон цахим хаягаар зэрэг тархаж байгаа эсэхийг шинжилнэ ([European External Action Service, 2025, 2026](#)).

Гуравдугаарт, эх сурвалжийн үнэн зөв, баталгааг шалгана. Анхны эх сурвалж, баримт бичиг, огноо, зураг болон бичлэгийн гарал, үйл явдлын газар, цаг хугацаа, албан ёсны тайлбар, холбогдох шалгалтын мэдээлэл хоорондоо нийцэж байгаа эсэхийг тогтооно ([European External Action Service, 2025, 2026](#)).

Дөрөвдүгээрт, үр нөлөөний чиглэлийг үнэлнэ. Тухайн агуулга бодит асуудлыг шийдвэрлэхэд чиглэж байна уу, эсхүл айдас, бухимдал, үл итгэх байдал, талцал, буруутгал, гомдлыг гүнзгийрүүлэхэд чиглэж байна уу гэдгийг шинжилнэ.



Зураг 4. Нөлөөллийн шинжийг үнэлэх дөрвөн шалгуур

Эдгээр шалгуурын нэгдсэн үнэлгээнд үндэслэн дараах гурван түвшний дүгнэлт хийж болно.

- *Мэдээллийн эрсдэлтэй агуулга:* эх сурвалж нь тодорхой бус, баталгаажуулалт шаардлагатай, олон нийтийг төөрөгдүүлэх магадлалтай мэдээлэл.
- *Зохион байгуулалттай байж болзошгүй нөлөөллийн шинж:* ижил өгүүлэмж, ижил хэллэг, хаягуудын давхцал, богино хугацаанд эрчимтэй түгээлт зэрэг зарим шинж илэрсэн боловч хангалттай нотолгоо бүрдээгүй нөхцөл.
- *Баталгаажсан зохион байгуулалттай ажиллагаа:* цахим ул мөр, хаягуудын хамаарал, санхүүжилтийн эх үүсвэр, автоматаар түгээсэн шинж, зохиомол хаяг, цахим талбарын шинжилгээ, эрх бүхий байгууллагын болон хараат бус шинжээчийн дүгнэлтээр нотлогдсон тохиолдол ([European External Action Service, 2025, 2026](#)).

3. Субъектийн боломжит зорилго

Бодит хэрэг, дүрмийн бус харилцаа, гэмт хэрэг, зөрчил, алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд учирсан эрсдэлтэй холбоотой мэдээллийг ашиглан нөлөөлөл үзүүлэхийг зорьж болзошгүй субъект дараах зорилгыг агуулж болно.

- *Төрийн байгууллагад итгэх итгэлийг сулруулах:* Нэг хэрэг, нэг анги, нэг удирдлагын түвшний доголдлыг батлан хамгаалах салбар бүхэлдээ ажиллахгүй байгаагийн нотолгоо мэтээр тайлбарлах нь төрийн байгууллага бүхэлдээ хяналтгүй, хариуцлагагүй, хүний эрхийг үл хүндэтгэдэг гэх ерөнхий ойлголт бий болгох эрсдэлтэй. Батлан хамгаалах салбарын байгууллагад итгэх олон нийтийн итгэл нь зөвхөн нэр хүндийн асуудал биш юм. Энэ нь цэргийн албаны нийгмийн үнэлэмж, иргэдийн оролцоо, алба хаагчдын сэтгэл зүй, ар гэрийн итгэл, батлан хамгаалах бодлогын хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдалтай шууд холбоотой ([Black et al., 2020; European External Action Service, 2025](#)).
- *Цэргийн албаны нийгмийн үнэлэмжийг бууруулах:* Цэргийн албыг бүхэлд нь аюултай, хүний эрх баталгаагүй, алба хаагч бүр зайлшгүй эрсдэлд ордог орчин

мэтээр туйлшруулан дүрслэх нь иргэдийн цэргийн албанд хандах хандлага, эцэг эх, ар гэрийн итгэл, цэргийн албаны талаарх нийгмийн ойлголтод сөргөөр нөлөөлж болзошгүй. Энэ нь бодит эрсдэлийг үгүйсгэх гэсэн санаа биш. Харин тодорхой хэрэг, зөрчил, шалтгаан нөхцөл, хариуцлагын асуудлыг шинжлэхийн оронд нэг тохиолдлыг бүх анги салбар, бүх алба хаагч, бүх цэргийн байгууллагын бодит байдал мэтээр тайлбарлах нь мэдээллийг гуйвуулан ашиглах хэлбэр болж болно ([Монгол Улсын Их Хурал, 2021, 2022](#); [Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2022](#)).

- *Дотоод итгэлцэл, сахилга, сэтгэл зүйд нөлөөлөх:* Алба хаагчдын дунд “удирдлага нууж байна”, “гомдол гаргавал хамгаалалтгүй”, “хүн бүр өөрийгөө л бодно” гэх ойлголт газар авбал байгууллагын дотоод итгэлцэл, сахилга, мэдээлэх соёл, хамтын ажиллагаа суларна. Энэ төрлийн нөлөөлөл нь гаднаас зохион байгуулалттай явсан эсэхээс үл хамааран бодит мэдээллийн хоосон орон зай, дотоод харилцааны сул байдлаас үүсэх боломжтой. Тиймээс байгууллагын удирдлага баталгаатай дотоод мэдээллийн сувгийг тогтмол ажиллуулах шаардлагатай ([Organisation for Economic Co-operation and Development, 2024](#); [United Nations Peacekeeping, 2024](#)).
- *Нийгмийн талцал, сэтгэл хөдлөлийн туйлшралыг бий болгох:* Хугацаат цэргийн алба, хүний эрх, сахилга, батлан хамгаалах зардал, цэргийн удирдлагын асуудлыг “иргэдийн тал” болон “цэргийн байгууллагын тал” гэсэн хоёр туйлт эсрэгцэл болгон хувиргах нь нийгмийн ойлголцлыг алдагдуулах эрсдэлтэй. Ийм нөхцөлд мэдээлэл нь шийдэл, нотолгоо, хариуцлага, шинэчлэлийн бодлогын тухай бус, харин буруутгал, айдас, гомдол, уур бухимдал, талцлыг өсгөхөд чиглэдэг. Үүний үр дүнд бодит асуудлыг бодлогын түвшинд хэлэлцэх боломж хумигдаж, мэргэжлийн дүгнэлт, хяналт-шинжилгээ, урьдчилан сэргийлэх бодит арга хэмжээний ач холбогдол буурч болзошгүй ([Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

Тав. Бодит эмзэг асуудал ба мэдээллийн нөлөөллийн эрсдэл

1. Дүрмийн бус харилцаа, хүний эрх, аюулгүй байдлын асуудал

Цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд, халдашгүй байх эрхтэй холбоотой аливаа тохиолдол нь нэн тэргүүнд хууль сахиулах байгууллагаар бүрэн, хараат бусаар шалгагдах ёстой. Ийм хэргийг улс төрийн ашиг, цахим хандалт, сурталчилгаа, байгууллагын нэр хүндийн маргааны хэрэгсэл болгох нь хохирогч, ар гэр, алба хаагчдын эрх ашигт сөрөг нөлөөтэй ([Монгол Улсын Их Хурал, 2021, 2022](#); [Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2022](#); [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2020, 2025](#); [News.mn, 2026](#)).

Дүрмийн бус харилцаа, сахилгын зөрчил, осол, гэмт хэрэг, амь нас болон эрүүл мэндэд хохирол учрах эрсдэл нь нэг л шалтгаантай байдаггүй. Үүнд захирагч, удирдах албан тушаалтны өдөр тутмын хяналт сулрах; алба хаагчдын дасан зохицол, сэтгэл зүйн тогтвортой байдлын эрт илрүүлэг хангалтгүй байх; гомдол, мэдээлэл гаргагчийн нууцлал, хамгаалалтад итгэх итгэл сулрах; эрх зүйн мэдлэг, өөрийгөө хамгаалах ойлголт жигд бус байх; хэт ачаалал, амралт, харуул хамгаалалт, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал; хүний нөөцийн сонгон шалгаруулалт, сургалт, сахилгын хяналт, манлайллын сул тал; цахилгаан, гал, барилга байгууламж, тээвэр,

техник хэрэгсэлтэй холбоотой аюулгүй ажиллагааны доголдол; дотоод мэдээллийн урсгал, албан ёсны тайлбар, эргэх холбооны хоцрогдол зэрэг хүчин зүйлс харилцан нөлөөлж болно (Монгол Улсын Их Хурал, 2021, 2022; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2022; Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2020, 2025).

Эдгээр нь мэдээллийн нөлөөллийн ажиллагааны шалтгаан биш. Харин бодит эмзэг асуудлыг нуун дарагдуулах, удаан хариу өгөх, ойлгомжгүй тайлбарлах нөхцөл бүрдвэл уг асуудал цахим орчин дахь манипуляцийн эмзэг цэг болж хувирч болно (Organisation for Economic Co-operation and Development, 2024; European External Action Service, 2025).



Зураг 5. Бодит эрсдэл ба мэдээллийн эрсдэлийн ялгаа

2. Бодит кейсийн сургамж

Олон улсын жишээнд мэдээллийн нөлөөллийн ажиллагаа нь ганц платформ, ганц хаяг, ганц сэдвээр хязгаарлагддаггүйг Европын Холбооны Гадаад харилцааны албаны тайлангууд харуулдаг. Гадаад мэдээллийн төөрөгдүүлэлт, хөндлөнгийн оролцоо нь олон цахим платформ, олон тооны хаяг, уялдаатай түгээлтийн сүлжээ ашиглаж, мэдээллийн орчин дахь итгэлцлийг сулруулах, олон нийтийн ойлголтыг төөрөгдүүлэх, төрийн болон нийгмийн институтийн тогтвортой байдалд нөлөөлөх зорилготой байж болзошгүйг тайланд тэмдэглэсэн байдаг (European External Action Service, 2025, 2026).

Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагааны судалгаанд 2023 онд асуулгад оролцсон энхийг сахиулагчдын 58 хувь нь ташаа болон зориудаар төөрөгдүүлсэн мэдээлэл ажиллагаанд нь ноцтой эсхүл маш ноцтой нөлөөлсөн гэж хариулсан байна. Тус байгууллага хортой мэдээлэл нь орон нутгийн иргэдийн итгэл, ажиллагааны үр нөлөө, алба хаагчдын аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэйг онцолж, урьдчилан бэлтгэсэн харилцааны төлөвлөгөө, шуурхай тайлбар, баталгаатай гол мэдээллийг чухалчилсан (Wardle, 2024; United Nations Peacekeeping, 2024).

Монголын нөхцөлд цэргийн салбар руу чиглэсэн тодорхой гадаад эсхүл дотоод субъектийн зохион байгуулалттай нөлөөллийн ажиллагаа явагдаж байгааг батлах нийтэд нээлттэй техникийн, санхүүгийн, сүлжээний нотолгоо хязгаарлагдмал байна. Иймд судалгааны хамгаалагдахуйц байр суурь нь тодорхой субъектийн

буруутай үйлдлийг баримтгүйгээр тогтоох бус, бодит хэрэг, зөрчлийг ашигласан мэдээллийн манипуляцийн эрсдэл байгааг тодорхойлж, түүнийг бууруулах бодлого боловсруулахад оршино. Гэсэн хэдий өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан Монгол Улсын өнөөгийн байдлын талаар товч авч үзлээ. ([European External Action Service, 2025, 2026](#))

Зургаа. Үр нөлөөний үнэлгээ

Нөлөөллийн ажиллагааны үр нөлөөг “хэчнээн нийтлэл гарсан бэ”, “хэчнээн хандалт авсан бэ”, “хэчнээн хүн хуваалцсан бэ” гэсэн тоон үзүүлэлтээр хязгаарлан хэмжих нь хангалтгүй. Мэдээллийн бодит нөлөө нь иргэдийн ойлголт, сэтгэл зүй, зан үйл, байгууллагын итгэлцэл, үйл ажиллагааны аюулгүй байдалд ямар өөрчлөлт бий болгосноор илэрнэ ([Organisation for Economic Co-operation and Development, 2024; European External Action Service, 2025](#)).

Үр нөлөөний түвшин	Боломжит үр нөлөө	Хэмжих үндсэн үзүүлэлт
Танин мэдэхүйн түвшин	Нэг хэрэг, нэг зөрчлийг бүх салбарын ерөнхий дүр зураг гэж ойлгох	Санал асуулга, агуулгын шинжилгээ, фокус бүлгийн ярилцлага
Сэтгэл зүйн түвшин	Айдас, бухимдал, үл итгэх байдал нэмэгдэх	Сэтгэл зүйн үнэлгээ, алба хаагч болон ар гэрийн судалгаа
Зан үйлийн түвшин	Баталгаагүй мэдээлэл дахин түгээх, нууцлалын зөрчил, албан бус гомдол нэмэгдэх	Дахин түгээлтийн хэв шинж, зөрчлийн тоо, мэдээлэх сувгийн ашиглалт
Байгууллагын түвшин	Итгэлцэл, сахилга, мэдээлэх соёл, нэр хүнд сулрах	Дотоод судалгаа, гомдлын бүтэц, сахилгын үзүүлэлт
Үйл ажиллагааны түвшин	Аюулгүй ажиллагаа, бэлэн байдал, олон нийттэй харилцах чадавхад эрсдэл үүсэх	Нууцлалын зөрчил, шийдвэрийн хугацаа, ажлын саатал, давхар тайлагнал
Аюулгүй байдлын түвшин	Цэргийн болон үндэсний аюулгүй байдалд эмзэг байдал үүсэх	Бэлэн байдлын бууралт, удирдлага-холбооны доголдол, мэдээллийн алдагдал



Зураг 6. Нөлөөллийн үр нөлөө үүсэх шатлал

Үр дүнд суурилсан шинжилгээнээс дараах үндсэн дүгнэлт гарна.

Нэгдүгээрт, нөлөөллийн ажиллагааны гол зорилго нь заавал тодорхой худал баримтыг үнэмшүүлэхэд оршдоггүй. Харин “юунд ч итгэж болохгүй”, “албан ёсны мэдээлэл худал”, “байгууллага асуудлаа нуудаг” гэх ерөнхий үл итгэх байдлыг бий болгох нь илүү урт хугацааны сөрөг үр дагавартай ([European External Action Service, 2025](#); [Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

Хоёрдугаарт, мэдээллийн дархлаа сул байх нь зөвхөн хувь хүний мэдлэгийн дутагдал биш бөгөөд байгууллагын дотоод мэдээллийн сувгийн сул байдал, удирдлагын харилцааны хоцрогдол, нууцлалын соёл, сэтгэл зүйн дэмжлэг, цахим хэрэглээний сахилга зэрэгтэй холбоотой ([Organisation for Economic Co-operation and Development, 2024](#); [United Nations Peacekeeping, 2024](#)).

Гуравдугаарт, худал мэдээллийг залруулах нь зайлшгүй боловч дангаараа хангалтгүй. Залруулга нь худал агуулга тархсаны дараа хийгддэг бол урьдчилсан тайлбар, эрт сэрэмжлүүлэг, албан ёсны мэдээллийн тогтмол урсгал, алба хаагчдын шүүн тунгаах чадвар нь эрсдэлийг үүсэхээс өмнө бууруулах ач холбогдолтой ([Council of Europe, 2017](#); [Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

Дөрөвдүгээрт, батлан хамгаалах салбар нь мэдээллийн нээлттэй байдал болон нууцлалын шаардлагын тэнцвэрийг барих ёстой. Хэт хаалттай байдал нь цуу ярианы орон зайг томруулж болох боловч хэт задгай харилцаа нь албаны болон нууц мэдээлэл алдагдах эрсдэл үүсгэнэ ([Монгол Улс, 2021](#); [Монгол Улсын Засгийн газар, 2022](#)).

Долоо. Мэдээллийн дархлаа, эрсдэлийн удирдлагыг сайжруулах чиглэл

1. Эрсдэлийн өөрийн үнэлгээнд мэдээллийн нөлөөллийн эмзэг байдлыг тусгах

Батлан хамгаалах байгууллагын эрсдэлийн өөрийн үнэлгээнд дараах шалгуурыг оруулах шаардлагатай ([Монгол Улсын Засгийн газар, 2022](#); [Монгол Улс, 2021](#)).

- Мэдээллийн хоосон орон зай үүсэх эрсдэл;
- Худал болон төөрөгдүүлсэн мэдээлэлтэй холбоотой эрсдэл;
- Хуурамч хаяг, сэжигтэй холбоос, цахим залилангийн эрсдэл;
- Хиймэл оюунаар бүтээсэн хуурамч агуулгын эрсдэл;
- Алба хаагчдын цахим сахилга, нууцлалын мэдлэг;
- Дотоод мэдээллийн урсгалын шуурхай байдал;
- Гомдол, мэдээлэх сувгийн найдвартай байдал;
- Байгууллагын нэр хүндэд чиглэсэн агуулгын давтамж;
- Алба хаагч, ар гэрийн мэдээллийн дархлааны түвшин.

Мэдээллийн нөлөөллийн эрсдэлийг байгууллагын эрсдэлийн бүртгэлд тусгах, эрсдэлийн магадлал болон үр дагаврыг үнэлэх, хариу арга хэмжээний эзэн, хугацаа, нөөц, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих, давтан үнэлгээ хийх шаардлагатай ([Монгол Улсын Засгийн газар, 2022](#)).



Зураг 7. Мэдээллийн дархлаа бэхжүүлэх тогтолцоо

2. Гомдол, мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх

Дүрмийн бус харилцаа, дарамт, хүчирхийлэл, аюулгүй ажиллагааны эрсдэлийн талаар мэдээлэхэд алба хаагч өөрийгөө хамгаалагдсан гэж мэдэрдэг байх шаардлагатай. Гомдол гаргагчийн нууцлал, аюулгүй байдал, хариу өгөх хугацаа, шийдвэрлэлтийн явц тодорхой бус бол бодит асуудал далдрах эрсдэлтэй (Монгол Улсын Их Хурал, 2021, 2022; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2022).

Далд үлдсэн асуудал нь дараа нь цуурхал, баталгаагүй мэдээлэл, хэт туйлширсан тайлбарын эх сурвалж болдог. Иймээс дотоод болон хараат бус гомдол, мэдээлэх сувгийг хялбар, нууцлалтай, хянагддаг, үр дүнтэй болгох шаардлагатай.

Үүнд нууцлалтай утас, цахим маягт, биечлэн уулзах олон хувилбарт суваг ажиллуулах; гомдол гаргагчийн эсрэг дарамт, ялгаварлал, өшөө авах үйлдлийг хориглох; мэдээлэл хүлээн авснаас хойш анхан хариу өгөх хугацааг тогтоох; шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн болон эрх зүйн зөвлөгөө үзүүлэх; шийдвэрлэлтийн явц, үр дүнг нууцлал алдагдуулахгүйгээр мэдээлэх; давтан гарсан асуудлын шалтгаан, нөхцөлийг удирдлагын түвшинд хэлэлцэх арга хэмжээ багтана (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2022; Монгол Улс, 2021).

3. Шуурхай, шаталсан мэдээллийн горим

Цэргийн байгууллага бодит хэрэг, зөрчил гарсан үед нууцлал, мөрдөн шалгах ажиллагаа, хохирогчийн эрх, олон нийтийн мэдээлэл авах эрхийг тэнцвэржүүлсэн шаталсан горимоор мэдээлэл өгөх нь зохистой (Монгол Улс, 2021; Монгол Улсын Засгийн газар, 2022).

Үе шат	Мэдээллийн агуулга
Анхны мэдэгдэл	Үйл явдал гарсан, холбогдох байгууллага шалгаж эхэлсэн тухай баталгаатай товч мэдээлэл
Сэрэмжлүүлэг	Баталгаагүй агуулга түгээхгүй байх, хувийн нууц болон мөрдөн шалгах ажиллагааг хүндэтгэх сануулга
Явцын мэдээлэл	Хуульд харшлахгүй хүрээнд шалгалтын явц, авсан хамгаалалтын арга хэмжээ
Эцсийн мэдээлэл	Эрх бүхий байгууллагын дүгнэлт, хариуцлага, шийдвэр
Сургамжийн мэдээлэл	Давтан эрсдэлийг бууруулах журам, сургалт, хяналтын шинэ арга хэмжээ

4. Алба хаагч, ар гэрийн мэдээллийн дархлааг бэхжүүлэх

Батлан хамгаалах байгууллагын мэдээллийн дархлаа, нөлөөллийн ажиллагаанд тэсвэрлэх чадавхыг дараах гурван түвшинд хөгжүүлэх шаардлагатай.

Нэгдүгээр түвшин. Алба хаагчийн мэдлэг, ур чадвар: Алба хаагч бүр эх сурвалж нягтлах, мэдээллийн огноо, байршил, эх үүсвэрийг шалгах, баталгаагүй холбоос болон файл нээхгүй байх, албаны нууц хадгалах, цахим сүлжээнд хариуцлагатай оролцох мэдлэгтэй байх шаардлагатай. Сургалтад дараах агуулгыг тогтмол оруулна ([Монгол Улс, 2021](#); [Монгол Улсын Засгийн газар, 2022](#); [Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

- Эх сурвалж нягтлах анхан шатны арга;
- Баталгаагүй агуулгыг таних шинж;
- Хиймэл оюунд суурилсан хуурамч агуулгын эрсдэл;
- Цахим орчны нууцлал, аюулгүй байдлын дэглэм;
- Байгууллагын нэр хүнд, алба хаагчийн цахим ёс зүй;
- Сэтгэл хөдлөлд суурилсан агуулгыг шүүн тунгаах дадал;
- Хуурамч баримт бичиг, хуурамч цахим хаяг, хуурамч мэдэгдлийг таних чадвар;
- Баталгаагүй мэдээллийг дахин түгээхгүй байх сахилга.

Хоёрдугаар түвшин. Байгууллагын мэдээллийн тогтолцоо: Байгууллага нь албан ёсны цахим хуудас, мэдэгдэл, тайлбар, сэрэмжлүүлэг, дотоод мэдээллийн сувгийн нэгдсэн горимтой байх шаардлагатай. Энэ тогтолцоо нь гомдол, цуурхал, худал мэдээлэл гарсан үед мэдээллийн хоосон орон зай үүсгэхгүй байх, баталгаатай тайлбар өгөх, хуурамч агуулгыг шуурхай залруулах, алба хаагч болон ар гэрт зориулсан сэрэмжлүүлэг хүргэх чиг үүрэгтэй байна ([European External Action Service, 2025](#); [Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

Гуравдугаар түвшин. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт: Мэдээллийн нөлөөллийн эрсдэлийг байгууллагын эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, нууцлал, кибер аюулгүй байдал, сэтгэл зүйн дэмжлэг, аюулгүй ажиллагааны төлөвлөлт, бэлэн байдлын үнэлгээтэй уялдуулан тусгах нь зүйтэй ([Монгол Улс, 2021](#); [Монгол Улсын Засгийн газар, 2022](#)).



Зураг 8. Нөлөөллийн эрсдэлийн хариу арга хэмжээний нэгдсэн загвар

5. Хэрэгжилтийн үр нөлөөг хэмжих шалгуур

Чиглэл	Үзүүлэлт
Мэдлэг	Эх сурвалж нягтлах, нууцлал, цахим аюулгүй байдлын мэдлэгийн түвшин
Зан үйл	Баталгаагүй агуулгын дахин түгээлт, мэдээллийн зөрчлийн өөрчлөлт
Мэдээлэх соёл	Сэжигтэй агуулга, гомдол, сэрэмжлүүлгийн мэдээллийн шийдвэрлэлтийн хувь
Байгууллагын хариу	Анхны мэдэгдэл, тайлбар, залруулга гаргах дундаж хугацаа
Итгэлцэл	Алба хаагч, ар гэр, иргэдийн итгэлцлийн судалгааны дүн
Эрсдэлийн бууралт	Давтан гарсан сахилгын болон мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн тоо
Сургалтын үр дүн	Хамрагдалт, дасгалын үнэлгээ, давтан шалгалтын ахиц

ДҮГНЭЛТ

Батлан хамгаалах салбар болон төрийн цэргийн байгууллагад гарч буй дүрмийн бус харилцаа, гэмт хэрэг, сахилгын зөрчил, алба хаагчдын амь нас, эрүүл мэндтэй холбоотой асуудал нь юуны өмнө хүний эрх, аюулгүй ажиллагаа, хариуцлагатай бодит асуудал мөн юм. Эдгээрийг нөлөөллийн ажиллагааны зохиомол үр дүн гэж шууд үзэх, тайлбарлах боломжгүй бөгөөд тусгайлсан нотолгоо, шинжилгээ шаардлагатай ажил юм. Гэхдээ үүнийг мөн аль нь болохыг шинжилж дүгнэн үзэхгүйгээр энд дурдагдсан олон эрсдэлд өртөж хохирол амсах эрсдэлтэй ([Монгол Улсын Их Хурал, 2021, 2022](#); [Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2022](#); [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2020, 2025](#); [News.mn, 2026](#)).

Гэвч ийм бодит эмзэг асуудалтай холбоотой мэдээллийн тодорхойгүй байдал, тайлбар, баталгаагүй “дотоод эх сурвалж”, нөхцөл байдлыг хэтийдүүлсэн тайлбарт агуулга, сэтгэл хөдлөл өдөөсөн гарчиг, зохиомол санал бодол, хиймэл оюунаар бүтээсэн хуурамч контент мэдээлэл нь салбарын болон байгууллагын нэр хүнд, төрд болон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдал, олон нийтийн итгэл, алба хаагчдын сэтгэл зүй, сахилга, бэлэн байдал цаашлаад үндэсний болон цэргийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бий болгоно ([European External Action Service, 2025, 2026](#); [Organisation for Economic Co-operation and Development, 2024](#)).

Нөлөөллийн ажиллагааг хэрэгжүүлэгч субъект нь гадаад талаас, төрийн бус сүлжээ, дотоодын ашиг сонирхлын бүлэг, цахим орчны ашиг хонжоо хайсан оролцогч, хувь хүн, санамсаргүй дахин түгээгч зэргээр олон түвшинд илэрч болно. Гэхдээ аливаа мэдээлэл, шүүмжлэл, иргэний хяналт, сэтгүүл зүйн эрэн сурвалжилгыг нөлөөллийн ажиллагаа гэж шууд нэрлэх нь буруу юм. Зохион байгуулалттай нөлөөлөл манипуляци гэж дүгнэхийн тулд агуулгын чиглэл, түгээлтийн давтамж, хаягуудын хамаарал, цахим ул мөр, санхүүжилтийн эх үүсвэр, техникийн шинжилгээ, бодит үр нөлөө, үүсэж болзошгүй эрсдэлийн салбарт илэрсэн байдал хэв шинж зэргийг хамтад нь авч үзэж дүгнэн нотлох шаардлагатай (Black et al., 2020; European External Action Service, 2025, 2026).

Хэрэв дээр дурдсан мэдээллийн урсгал, давтан түгээлт, хэтийдүүлж хавтгайруулсан дайралт зэрэг, баталгаагүй тайлбар нь бодитойгоор зохион байгуулалттай мэдээллийн нөлөөлөлт манипуляцийн шинжтэй байна гэж үзвэл тухайн нөлөөллийн ажиллагааны субъектүүдийн зорилго тодорхой хэмжээнд хэрэгжиж хангагдсан гэж үзэх үндэслэлтэй байна. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалах салбарын нэр хүнд, удирдлагад итгэх олон нийтийн итгэл, цэргийн албанд хандах хандлага, үнэлэмж, алба хаагчдын сэтгэл зүй, дотоод сахилга, мэдээлэх соёл, дайчилгааны нийгмийн сэтгэл зүйн бэлэн байдалд бодит сөрөг нөлөө үзүүлсэн, бэлэн байдал сургалт бэлтгэлийг цалгардуулж саармагжуулсан, улмаар салбар болон алба хаагчид өгүүлэлд дурдсан мэдээллийн нөлөөллийн эрсдэлүүдийн бодит хохирлыг амссан гэж таамаглан дүгнэж болно (European External Action Service, 2025, 2026).

Мэдээллийн нөлөөллийн эрсдэлийн эсрэг хамгийн үр нөлөөтэй хамгаалалт нь мэдээллийг хаах бус, бодит асуудлыг эрт илрүүлэх, шударгаар шалгах, хариуцлага тооцох, давтан эрсдэлийг бууруулах, алба хаагч болон ар гэрийн гомдол мэдээлэх эрхийг хамгаалах, нотолгоонд суурилсан шуурхай мэдээлэл өгөх, мэдээллийн дархлааг тогтмол бэхжүүлэх явдал болно. (Council of Europe, 2017; Organisation for Economic Co-operation and Development, 2024; United Nations Peacekeeping, 2024)

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. European External Action Service. 2025. *3rd EEAS Report on Foreign Information Manipulation and Interference Threats: Exposing the Architecture of FIMI Operations*. European External Action Service (EEAS).
2. European External Action Service. 2026. *4th EEAS Annual Report on Foreign Information Manipulation and Interference Threats*. European External Action Service (EEAS). https://www.eeas.europa.eu/sites/default/files/2026/documents/EEAS%204th%20Threat%20Report_web%20version_1.pdf.
3. Wardle, Claire, and Hossein Derakhshan. 2017. *Information Disorder: Toward an Interdisciplinary Framework for Research and Policy Making*. DGI(2017)09. Council of Europe.
4. Wardle, Claire. 2024. *A Conceptual Analysis of the Overlaps and Differences between Hate Speech, Misinformation and Disinformation*. United Nations Department of Peace Operations; Office of the Special Adviser on the Prevention of Genocide. https://peacekeeping.un.org/sites/default/files/report_-_a_conceptual_analysis_of_the_overlaps_and_differences_between_hate_speech_

[misinformation_and_disinformation_june_2024_qrupdate.pdf](#).

5. Монгол Улсын Их Хурал. 2022. *Монгол Улс Дахь Хүний Эрх, Эрх Чөлөөний Байдлын Талаарх 21 Дэх Илтгэлийг Хэлэлцлээ*. Монгол Улсын Их Хурал. <https://www.parliament.mn/nn/18462/>.
6. Black, J., Lynch, A., Gustavsson, L., Rydqvist, J., & Persson, M. (2020). *Deterrence and defence in the grey zone: A case study of NATO and Russia*. RAND Corporation.
7. Council of Europe. (2017). *Information disorder: Toward an interdisciplinary framework for research and policy making*. Council of Europe.
8. European External Action Service. (2025). *3rd EEAS report on foreign information manipulation and interference threats*. European Union.
9. European External Action Service. (2026). *4th EEAS annual report on foreign information manipulation and interference threats*. European Union.
10. Монгол Улс. (2021). *Кибер аюулгүй байдлын тухай хууль*.
11. Монгол Улсын Засгийн газар. (2022). *Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги*. Засгийн газрын 493 дугаар тогтоолын хавсралт.
12. Монгол Улсын Их Хурал. (2021). *Төрийн цэргийн байгууллага дахь хүний эрхийн асуудлаарх хэлэлцүүлгийн мэдээлэл*.
13. Монгол Улсын Их Хурал. (2022). *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай мэдээлэл*.
14. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс. (2022). *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл*.
15. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан. (2020). *Зэвсэгт хүчний 123 дугаар ангид гарсан захирагч захирагдагчаа зодсон хэргийн шүүхийн шийдвэр*.
16. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан. (2025). *Зэвсэгт хүчний 327 дугаар ангид гарсан цэргийн дүрмийн бус харилцаа, хүч хэрэглэсэн хэргийн шүүхийн шийдвэр*.
17. News.mn. (2026, May 21). *ХЭҮК: Хоёр цэргийн албан хаагч зодолдсоноос нэгнийх нь амь нас хохирсон хэрэгт анхаарч байна*.
18. Organisation for Economic Co-operation and Development. (2024). *Facts not fakes: Tackling disinformation, strengthening information integrity*. OECD Publishing.
19. United Nations Peacekeeping. (2024). *A conceptual analysis of the overlaps and differences between hate speech, misinformation and disinformation*.
20. Wardle, C., & Derakhshan, H. (2017). *Information disorder: Toward an interdisciplinary framework for research and policy making*. Council of Europe.